



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар ХЭГ/1919

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Л.ЭНХБОЛД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Тавантолгойн бүлэг орд газарт хууль бусаар нүүрс олборлож, хилээр гаргасан нөхцөл байдлыг шалгах ажиллагааны явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0008145



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хог, Сүхбаатар дүүрэг,

Их тойруу 81/1, Утас/Факс (976-11) 35 00 60,

И-мэйл: info@customs.gov.mn, Вэбсайт: www.customs.gov.mn

2019.06.04 № 02/2018  
ганай 2019.05.30 -ны № 246318 -т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
С.НАРАНЦОГТ ТАНАА

### Асуулгын хариуны талаар

Сангийн сайдын 2018 оны 109 тоот тушаалаар байгуулагдсан "Таван толгой" ХК-ийн үйл ажиллагааг шалгах ажлын хэсгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Гаалийн байгууллага 15 хүний бүрэлдхүүнтэй ажлын дэд хэсгийг Гаалийн ерөнхий газарт байгуулж 45 хоног ажлын уртасгасан цагаар ажиллуулж Тавантолгой ХК-ийн санхүүгийн анхан шатны баримт, гадаад худалдааны гэрээг гаалийн бүрдүүлэлттэй тулган шалгасан үйлдлийн талаар УИХ-ын гишүүн Л.Энхболдын тавьсан асуулгад дараах хариултыг хүргүүлж байна. Үүнд:

1. "Тавантолгой транс" компанийн 2013-2017 онд "Тавантолгой" ХК-тай 11 660 000 тн нүүрс авахаар гэрээ байгуулсан боловч Тавантолгой ХК-ийн санхүүгийн анхан шатны баримтаар "Тавантолгой транс" ХХК-нь 1 793 248,67 тн нүүрс худалдан авсан ба Гашуунсухайт гаалийн газраар 2 185 463,95 тн нүүрсийг экспортлосон нь худалдаж авсан нүүрсний тоо хэмжээнээс хэтэрсэн байсанг тогтоож илүү нүүрсний эх сурвалжийг тодруулах ажлыг цагдаад шилжүүлсэн.
2. Ажлын хэсгийн шалгалтын хүрээнд Гаалийн байгууллагад хоосон гэж мэдүүлсэн 3982 нүүрс тээвэрлэгч автомашин нь давтамж өндөртэй олон удаа хоосон гэж улсын хилээр гарсан байсан тул шалгуулахаар Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.
3. Гаалийн байгууллагын гаргасан тээврийн хэрэгслийн тоо Хил хамгаалах газрын гаргасан тээврийн хэрэгслийн тоо 35000 орчим зөрүүтэй байгаа талаар ажлын хэсэг дээр яригдаж машин тус бүрээр тулгалт хийхэд Хил хамгаалах газрын гаргасан тээврийн хэрэгсэлийн тоо нь улсын хилээр гарсан ачаа, суудлын машины нийт тоо хэмжээ, харин гаалийн байгууллагын гаргасан тээврийн хэрэгслийн тоо нь зөвхөн нүүрс тээвэрлэсэн том оврын ачааны машины тоо тул 2 байгууллагын улсын хилээр нэвтэрсэн машины тоо зөрүүтэй байгааг ажлын хэсэг дээр танилцуулсан болно.
4. 2011-2013-оны хооронд Гаалийн байгууллага дотоод хяналт шалгалтыг Гашуунсухайт боомтын үйл ажиллагаанд оруулж 379000 тн нүүрсийг хууль бусаар улсын хилээр гаргасан байх магадлалыг тогтоож тухайн цаг хугацаанд

0002560

Цагдаагийн байгуулагад шилжүүлсэн бөгөөд хэргийг хэрэгсэхгүй болгосон мэдээлэл ажлын хэсгийн хурал дээр авсан.

Дээрх ажлын хүрээнд Гаалийн байгуулага хийж хэрэгжүүлсэн бусад ажлуудаас:

Гаалийн байгууллага 2013-2017 оны Тавантолгой ХК-ний экспортлосон нүүрсийг БНХАУ-ын Ганц мод боомтоор импортлосон нүүрсний тоо хэмжээтэй тулгалт хийх зорилгоор мэдээлэл авах талаар БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар болон Хөх хотын гаалийн цагдаагийн удирдлагуудтай 3 удаагийн уулзалтыг хийж мэдээллийг авч Сангийн яаманд гаргаж өгсөн.

Мөн хоосон гарсан гэх 3982 машины мэдээллийг БНХАУ-ын Ганц мод боомтоор орсонтой тулгалт хийхэд манай экспортлосон нүүрсний тоо хэмжээ нь зөрүүтэй байгааг тодорхойлж Цагдаагийн байгуулагаар шалгуулахаар шилжүүлсэн.


Гашуунсухайт гаалийн газарт нүүрс тээвэрлэж буй 10 машинтай өөр эзэмшигчтэй, ижил улсын дугаартай, арлын дугаартай 10 ш том оврын чирэгч, чиргүүл нь Сүхбаатар аймгийн Бичигт боомтоор явж байсаныг тогтоож Цагдаагийн байгуулагад шилжүүлсэн.

Цаашид гарч буй зөрчлийг арилгах арга хэмжээний хүрээнд улсын хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгслийг шалгах, бүртгэх ажлыг ухаалаг технологи хэрэгжүүлж хянах, мэдээллийн сан үүсгэх нэгдсэн удирдлагаар хангах шуурхай хяналтын удирдлагын төв байгуулж хяналтын бүсүүдыг бүрэн камержуулах ажил хийгдэж байна.

Гаалийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх, автоматжуулах, бараа бүтээгдхүүнд шуурхай шинжилгээ хийх, үр дүнг тухай бүр тодорхойлох болон Улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслүүдийг цахим хэлбэрээр бүртгэх, дүрсийг буулгах, жин тонн, даацыг шуурхай тодорхойлох ажлууд хийгдэж байна.

Мөн хилийн боомтуудыг хөгжүүлж олон улсын стандартад нийцүүлэх төсөл арга хэмжээнүүдийг Гашуунсухайт, Шивээхүрэн, Бичигт, Замын-Үүд, Увс, Алтанбулаг боомтуудад эхлүүвэл байна.

ДЭД ДАРГА



Е. БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо.

Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087.

Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2019.06.04 № 4/292  
танай 2019.05.30 -ны № 13-4/3518 -Т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
С.НАРАНЦОГТ ТАНАА

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболдын Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан "Тавантолгойн бүлэг орд газарт хууль бусаар нүүрс олборлон борлуулж, эрх мэдэл, албан тушаалаа урвуулан, улсад онц их хэмжээний хохирол учруулсан байж болзошгүй" талаарх асуулгын дагуу дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. "Эрдэнэс-Таван толгой" ХК-ий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас алдагдсан гэх нүүрсний бодит хэмжилтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас томилсон итгэмжлэгдсэн компанийн маркшейдерийн хэмжилтээр 340.092.98 тонн нүүрс хил даван олборлосон гэж тогтоосон байна. Тухайн 340.092.98 тонн нүүрсийг хэн, хэрхэн, яаж олборлосон талаар болон тухайн нүүрсний төлбөр нь төлөгдсөн эсэх талаар. Мөн хууль хяналтын байгууллагууд дээр алдагдсан нүүрсний хэргийн шалгалтын явц ямар шатандаа байгаа, энэ талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар:

- Дээрх асуудалд Авлигатай тэмцэх газар харьяаллын дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

2. Гаалийн ерөнхий газрын ажлын хэсгийн дүгнэлтээр "Тавантолгой транс" ХХК нь 2013-2017 онуудад "Тавантолгой" ХК-иас 1.795.128.82 тонн нүүрс худалдан авсан бол 2013-2017 онуудад нийт 2.185.463.95 тонн нүүрс экспортолсон байна. Балансаар харахад 390.335.13 тонн нүүрсний зөрүү гарч байна. Дээрх илүү гарсан 390.335.13 тонн нүүрсний эх үүсвэр нь тодорхой бус тул хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гардаг. Гааль, хил хамгаалах байгууллагууд тус эх үүсвэр нь тодорхойгүй гаргасан нүүрсний талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар:

- Дээрх асуудалд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 180200318 дугаартай хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагаагаар "Таван толгой" ХК-ий 2013-2017 оны санхүүгийн анхан шатны баримтад хөндлөнгийн аудитын компаниар санхүүгийн шинжилгээ хийлгэж, урьдчилсан байдлаар дүгнэлт гарсан ба хилээр илүү нүүрс экспортод гаргасан аж ахуйн нэгжүүд 2012 онд хэдий хэмжээний нүүрс худалдан авсан эсэхийг аудитын компаниар тогтоолгохоор ажиллаж байна.

"Таван толгой" ХК-иас нүүрс худалдан авсан аж ахуйн нэгжүүд нь нүүрс худалдсан мөнгөө өөрсдийн дансаар авдаггүй, худалдан авагч БНХАУ-ын компани нь шууд "Таван толгой" ХК-ий дансанд мөнгийг шилжүүлж байсан нь татвараас зайлсхийх гэмт хэрэг байж болзошгүй тул Татварын ерөнхий газарт аж ахуйн

0903732

нэгжүүдийг шалгуулахаар хүргүүлсэн боловч ажлын ачаалал их байгаа гэх шалтгаанаар шалгалтын ажиллагаа хийгдээгүй байна.

Цагдаагийн байгууллагаас БНХАУ-д улсад импортоор оруулсан нүүрсний хэмжээ, түүнийг тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн жагсаалтыг аж ахуйн нэгж бүрээр 2013-2017 оны байдлаар гаргуулан авахаар БНХАУ-ын Элчин сайдын яаманд 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10а/448 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл хариу ирүүлээгүй байна.

3. Хил хамгаалах ерөнхий газраас гаргасан мэдээгээр 2013-2017 онуудад Гашуунсухайт боомтоор нийт 849.141 автомашин хилээр гарсан байгаа бол Гаалийн ерөнхий газрын мэдээгээр мөн онуудад 814.243 автомашин нүүрс тээвэрлэсэн тухай бүртгэлтэй байна. Дээрх 2 байгууллагын бүртгэлийн зөрүүнээс харахад 35.000 орчим автомашин хилээр хоосон гарсан байж болзошгүй байна. Үүнээс Гаалийн ерөнхий газрын бүртгэлээр 2013-2017 онуудад Гашуунсухайт боомтоор 2527 автомашин, 17124 удаагийн давтамжтай хоосон гарсан бүртгэлтэй байгаагаас 59 аж ахуйн нэгжийн 3982 автомашин олон удаагийн давтамжтайгаар хилээр хоосон гарсан нь нүүрс тээвэрлэсэн байх магадлалтай тул шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлсэн оловч одоог хүртэл ямар арга хэмжээ авсан талаар мэдээлэл огт байхгүй байна. Энэ талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын явц болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар:

- Дээрх асуудалд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 180200318 дугаартай хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад "Таван толгой" ХК нь аж ахуйн нэгжүүдтэй 2013-2017 онд 48.4 сая тн нүүрс борлуулахаар гэрээ байгуулсан боловч 12.7 сая тн буюу 26.3 хувийг нийлүүлсэн, экспортод гаргахаар худалдан авсан нүүрснээс 19 аж ахуйн нэгж 590.9 мянган тн нүүрс илүү хэмжээгээр хилээр гаргасан нь Гаалийн ерөнхий газрын мэдээгээр тогтоогдсон.

Өмнөговь аймгийн Гашуунсухайтын боомтоор 2013-2017 онд нийт 2527 автомашин 17124 удаагийн давтамжтайгаар хилээр ачаагүй хоосон гарсан талаар Гаалийн ерөнхий газрын мэдээллийн санд бүртгэгдсэнийг автомашин тус бүрээр нь тулгах ажиллагаа хийгдэж байна.

"Эрдэнэс Монгол" ХК-иас хилээр 625 тээврийн хэрэгсэл 3955 удаа хилээр хоосон гарсан мэдээллийг цаг хугацааны давтамжаар нь гаргуулахаар 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 10а/1284, Гаалийн ерөнхий газраас дээрх тээврийн хэрэгслүүдийн улсын хилээр нэвтрэхдээ бүрдүүлсэн гаалийн бүрдүүлэлтийн материалыг гаргуулахаар энэ оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10а/1310 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн боловч одоогоор хариу ирүүлээгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад энэ оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2/281 дүгээр албан бичгээр дээрх асуулгын талаар мэдээлэл хүргүүлсэн болохыг танилцуулья.

Хүндэтгэсэн,

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

РОТГОНЖАРГАЛ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР**

13343 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Б Доржийн гудамж, Утас: 26-66-38, Факс: (976-51) 26-41-43  
E-mail: border\_pgb@bpo.gov.mn, http://bpo.gov.mn

2019 06 05 № 1/8187  
Танай 2019 05 30 -ны № 13-2/3518 -Т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
С.НАРАНЦОГТ ТАНАА

*С. Наранцогт*  
*Ц.Сэргэлэн*

Хариу хүргүүлэх тухай

Таны 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 13-2/3518 дугаар албан бичгээр ирүүлсэн Улсын их хурлын гишүүн Л.Энхболдоос Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд тавьсан асуулгатай танилцлаа.

Хил хамгаалах байгууллага нь "Монгол Улсын хилийн тухай хууль"-ийн дагуу "Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах" чиг үүргийг хэрэгжүүлж, хилийн боомтоор нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн жолооч нарын улсын хил нэвтрэх эрхийн баримт бичгийг шалгаж, хил нэвтэрсэн тэмдэглэл үйлддэг бөгөөд хилийн боомтоор экспортолж буй нүүрсний эх үүсвэр, тоон үзүүлэлтийг Гаалийн байгууллага хариуцан гаргадаг.


Иймд Улсын их хурлын гишүүн Л.Энхболдын асуулгад дурдсан асуудлууд нь тус байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамааралгүй болохыг уламжилъя.

Улсын их хурлын гишүүн Л.Энхболдоос 2018 онд тус байгууллагад хандаж хилийн "Гашуунсухайт", "Шивээхүрэн" боомтоор 2016, 2017 онд БНХАУ-д экспортолсон нүүрсний талаарх мэдээлэл ирүүлэхийг хүссэн хүсэлтэд өгсөн хариу албан бичгийн хуулбарыг хавсаргав.

Хавсралт 5 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ц.СЭРГЭЛЭН



139

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Л.ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

13343 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Утас/Факс: (976-51) 26-66-38, 26-41-43  
border\_pgb@bpo.gov.mn; http://www.bpo.gov.mn

2018.04.23 № 1/2980

Хил 35.1.6 -ны № 4129 -г

Тайлбар, мэдээлэл хүргүүлэх  
тухай

Таны 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 4129 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу дараах тайлбар, мэдээллийг хүргүүлж байна.

1.Хил хамгаалах байгууллага нь 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс цордөгдөж эхэлсэн Монгол Улсын хилийн тухай хуулийн дагуу улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх чиг үүргийг Гадаадын иргэн, харьяатын газраас хүлээн авсан.

Дээрх хуулийн 35.1.6 дахь заалтад заасан *"Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах"* чиг үүргийн дагуу Хил хамгаалах байгууллага улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийг хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг баримтлан шалган нэвтрүүлж байна.

Энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ зорчигчийн баримт бичигт хуурмаглал хийсэн, бусдын баримт бичгийг ашигласан, хүчин төгөлдөр бус баримт бичгээр хил зорчсон, зөрчихийг завдагсадыг илрүүлэх, олон улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа онц аюултай гэмт хэрэгтэн, алан хядах байгууллагын гишүүн, гэмт хэрэг үйлдэн гадаадад оргон зайлж болзошгүй гэж хуулийн байгууллагаас хил нэвтрэх эрхийг нь түр түдгэлзүүлсэн болон хязгаарласан этгээд мөн бишийг тогтоох, тэдний зүгээс учруулж болзошгүй халдлагаас бусад зорчигчдийг хамгаалах зорилгоор зорчигчийн хил нэвтрэх эрхийн баримт бичиг эх илгвартайгаа тохирч байгаа эсэх, баримт бичиг эзэмшигчийг иргэний үндсэн мэдээллийн болон хилээр үл нэвтрүүлэх, саатуулах иргэдийн мэдээллийн нэгдсэн сантай тулгалт хийж, баримт бичгийн баталгаажилт, хүчин төгөлдөр эсэхийг шалган, зөрчилгүй баримт бичигт хил нэвтэрсэн тухай тэмдэглэл хийж, улсын хилээр нэвтрүүлдэг.

Мөн хуулийн 17.6 дахь зүйлд "Улсын хил хамгаалах байгууллага нь зөрчигчийн улсын хил нэвтрэх эрхийн баримт бичигт тэмдэглэл хийж, улсын хил нэвтрэсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтөлж нэгдсэн сан байгуулна" гэж зааснаар зорчигч, тээврийн хэрэгслийн тоон мэдээллийг суудлын, ачааны, автобус болон бусад төрлийн гэж ангилан "Зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэдэг болно.

2.Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилийн тухай хуулийн 36.1.5 дахь заалтад заасан "Улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэлд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх явцад илэрсэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зүйлийг хураан авч, холбогдох байгууллагад шилжүүлэх" эрхийн хүрээнд зорчигчийн хөлөглөж яваа автомашинд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийж, үзлэгийн явцад илэрсэн зэвсэг, галт хэрэгсэл, хар тамхи мансууруулах бодис, соёл, түүх, археологийн үнэт олдвор зэрэг хориглосон болон хязгаарласан эд зүйлийг хураан авч, холбогдох байгууллагад шилжүүлдэг.

Тус байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгт улсын хилээр нэвтэрч байгаа экспорт, импортын бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх, бүртгэх үүрэг хамаардаггүй.

Хилийн хяналтын байгууллагууд, хилийн боомтод тус тусын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хяналт шалгалт явуулахдаа улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд мэргэжлийн хяналтын, гаалийн, улсын хил хамгаалах байгууллага, улсын хилээр орох хөдөлгөөний чиглэлд улсын хил хамгаалах, мэргэжлийн хяналтын, гаалийн байгууллага гэсэн дарааллыг баримталдаг.

Гаалийн хяналт шалгалтаар орж, гаалийн бүрдүүлэлт хийсэн тээврийн хэрэгсэлд Хил хамгаалах байгууллага хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийж, зөвхөн тээврийн хэрэгслийн жолоочийн хил нэвтрэх эрхийн баримт бичигт тэмдэглэл хийдэг.

Гаалийн тухай хуулийн 9.1 дэх зүйлд "Гаалийн байгууллага, албан тушаалтан нь улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх...." гэж, мөн тус хуулийн 274.1.1 дэх зүйлд гаалийн улсын байцаагчийн үүргийг "Энэ хуульд заасны дагуу гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж бүрдүүлэлт хийх" гэж хуульчилсны дагуу Гаалийн байгууллага улсын хилээр нэвтэрч байгаа бараа, бүтээгдэхүүнд гаалийн бүрдүүлэлт хийж, бүртгэлд авч, хяналт шалгалт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг.




Таны ирүүлсэн албан бичигт дурьдсан Монгол, БНХАУ-ын 2016 оны чулуун нүүрсний мэдээллийн зэрэгцүүлэлтээс импортолсон нүүрсний хэмжээ нь экспортолсон хэмжээнээс 463.926 тонноор илүү байгаатай холбоотой асуудалд Гаалийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд бодитой мэдээллийг гаргах боломжтой.

Харин Хил хамгаалах байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 291 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 00.00 цагаас 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 12.00 цаг хүртэл улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоон мэдээллийг, мөн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудаар 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоон мэдээллийг тухайн үеийн Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний ерөнхий газраас "Зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-д бүртгэгдсэн байдлаар гарган хүргүүлэв.

Хавсралт ~~2~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ц.СЭРГЭЛЭН

Гашуунсухайт, шивээхүрэн боомтуудаар улсын хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн судалгаа

/ХХЕГ шалган нэвтрүүлэх албаны чиг үүргийг хэрэгжүүлж эхэлсэн үеэс хойших судалгаа/

/2017.02.01-ний өдрийн 00:00 цагаас 2018.04.18-ны өдрийн 12:00 цаг хүртэл/

Гашуунсухайт авто замын боомт	Гарах					Орох					Бүгд	
	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл	Бусад	Нийт	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл		Бусад
79	304775	14932	307346	13	627145	78	305765	14636	307354	91	627924	1255069

/2017.02.02-ны өдрийн 15:00 цагаас 2018.04.18-ний өдрийн 12:00 цаг хүртэл/

Шивээхүрэн авто замын боомт	Гарах					Орох					Бүгд	
	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл	Бусад	Нийт	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл		Бусад
80	163161	8786	162570	3	334600	76	163928	8762	163257	7	336030	670630

Жлч: Бусад тээврийн хэрэгсэлд мотоцикл, дугуй, өөрөө явагч тээврийн хэрэгсэл, механизмуд багтана.

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

Хил хамгаалах ерөнхий газрын, 2018 оны ОХУ дүгээр сарын 03-ны өдрийн /... дүгээр албан бичгийн хавсралт. /2580

ГАСУУНСУХАЙТ, ШИВЭЭХҮРЭН БООМТУУДААР УЛСЫН ХИЛ НЭВТЭРСЭН ТЭЭВРИЙН ХЭВЭГЭДИЙН СУДАЛГАА  
/ИХШХЕГ шалган нэвтрүүлэх албаны чиг үүргийг хэрэгжүүлж байх үеийн судалгаа/

/2016.01.01-ний өдрийн 00:00 цагаас 2017.02.01-ний өдрийн 12:00 цаг хүртэл/

Гашуунсухайт авто замын боомт	Гарах						Орох				Нийт		
	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл	Бусад	Бүгд	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл		Бусад	Бүгд
11		242555	13697	198086	503	454852	11	243192	13439	197556	500	454698	909550

/2016.01.01-ний өдрийн 00:00 цагаас 2017.02.02-ны өдрийн 15:00 цаг хүртэл/

Шивээхүрэн авто замын боомт	Гарах						Орох				Нийт		
	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл	Бусад	Бүгд	Автобус	Ачааны машин	Суудлын машин	Чиргүүл		Бусад	Бүгд
112		132472	8922	103633	2	245141	118	132693	8693	103696	4	245204	490345

Жич: Бусад тээврийн хэрэгсэлд мотоцикл, дугуй, өөрөө явагч тээврийн хэрэгсэл, механизмүүд багтана.

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.ЭНХБОЛДООС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Асуулга 1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас алдагдсан гэх нүүрсний бодит хэмжилтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас томилсон итгэмжлэгдсэн компанийн маркшейдерийн хэмжилтээр 340.092.98 тонн нүүрс хил даван олборлосон гэж тогтоосон байна. Тухайн 340.092.98 тонн нүүрсийг хэн, хэрхэн, яаж олборлосон талаар болон тухайн нүүрсний төлбөр нь төлөгдсөн эсэх талаар, мөн хууль хяналтын байгууллагууд дээр алдагдсан нүүрсний хэргийн шалгалтын явц ямар шатандаа байгаа, энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:**

Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Сангийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 109 дүгээр тушаал болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 01/174 тоот удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас хил даван “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нэвтэрч, их хэмжээний нүүрс олборлосон гэх асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах зорилго бүхий Ажлын хэсэг хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хяналт шалгалтаар “Тавантолгой” ХК нь уурхайн 4 дүгээр амны зүүн, зүүн хойд хэсэгт IVa давхаргын таазнаас олборлолт явуулсан, 4 дүгээр амны хойд хэсэгт IVa давхаргын таазнаас олборлолт явуулсан, 4 дүгээр амны зүүн хойд хэсэгт IVb давхаргын хэсэгт олборлолт явуулсан, 4 дүгээр амны баруун хэсэгт IVa давхаргын хэсгүүдээр зааглагдан нийт таван хэсэгт 340,092.98 тонн нүүрс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлосныг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага “Хос Алтан Пирамид” ХХК-ийн хийсэн маркшейдерийн хэмжилтээр тогтоосон байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь уурхайн талбайн аюулгүй байдал, шав тэмдгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалаагүйгээс орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК-ийн ашиглалтын MV-016882, MV-011943 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хилийг даван нүүрс олборлох үйл ажиллагаа эхлэхэд таслан зогсоох арга хэмжээ авч ажиллаагүй нь хууль бусаар нүүрс олборлох нөхцөлийг бүрдүүлсэн гэж Ажлын хэсэг дүгнэсэн.

Авлигатай тэмцэх газрын 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 09/236 дугаар албан бичигт “Тавантолгой” ХК, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хамтарсан баг 2015, 2016 онд 3 удаагийн хэмжилт хийж, “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 268.3 мян.тн нүүрс олборлосон, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны а/86 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Их нэмүүн” ХХК-аар хэмжилт хийлгэхэд “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас 267.68 мян.тн нүүрс олборлосон, МХЕГ-ын даргын 2018 оны 01/174 тоот удирдамжаар батлагдсан Ажлын хэсэг “Хос Алтан Пирамид” ХХК-иар хэмжилт хийлгэхэд “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 340,092.98 тонн нүүрс олборлосон тухай зөрүүтэй 3 тайлан гарсан байгаа талаар дурдсан.

Мөн дээрх зөрүүтэй байдлаас үүдэн хөндлөнгийн маркшейдерийн байгууллагаар хэмжилт хийлгэж, нэгдсэн, үнэн зөв, үндэслэл бүхий тооцоололтой дүгнэлт, тайлан гаргуулах тухай албан хүсэлтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Уг хүсэлтийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн А/21 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Маркшейдерийн холбоо, "Тавантолгой" ХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төлөөллийг оролцуулсан хөндлөнгийн геологи, маркшейдерийн хэмжилт хийлгэн нэгдсэн үнэн зөв үндэслэл бүхий тооцоололтой дүгнэлт, тайлан гаргуулах үүрэг бүхий Ажлын хэсэг болон дүгнэлт, тайлан гаргах үүрэг бүхий геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг тус тус байгуулан ажилласан.

Хөндлөнгийн тайлан гаргуулах үүрэг бүхий ажлын хэсэг маркшейдерийн хяналтын хэмжилт хийх байгууллагыг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулах Ажлын хэсэгт хүргүүлснээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Тендерийн бичиг баримтыг боловсруулан 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдөр цахим тендер зарласан бөгөөд 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 11:30 минутад нээхэд аж ахуйн нэгжүүдээс тухайн тендерт оролцох санал ирүүлээгүй тул дахин 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 2-ны хооронд 7 хоногийн хугацаатай зарласан боловч мөн тухайн тендерт оролцох саналыг ирүүлээгүй болно.

Иймд хөндлөнгийн маркшейдерийн хяналтын хэмжилтийг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах боломжгүй болсон тул Ажлын хэсгээс хуульд заасан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар Авлигатай тэмцэх газарт 2019 оны 4 дүгээр сарын 10-ны 03/1236 дугаар албан бичгийг хүргүүлэн ажилласан болно.

"Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас алдагдсан гэх 340.092.98 тонн нүүрсийг хэн, хэрхэн, яаж олборлосон болон тухайн нүүрсний төлбөр нь төлөгдсөн эсэх асуудалд Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

**Асуулга 2. Гаалийн ерөнхий газрын ажлын хэсгийн дүгнэлтээр "Тавантолгой транс" ХХК нь 2013-2017 онуудад "Тавантолгой" ХК-иас 1.795.128.82 тонн нүүрс худалдан авсан бол 2013-2017 онуудад нийт 2.185.463.95 тонн нүүрс экспортолсон байна. Балансаас харахад 390.335.13 тонн нүүрсний зөрүү гарч байна. Дээрх илүү гарсан 390.335.13 тонн нүүрсний эх үүсвэр нь тодорхой бус тул хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байдаг. Гаалийн байгууллага, хил хамгаалах байгууллагууд тус эх үүсвэр нь тодорхойгүй гаргасан нүүрсний талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар:**

"Тавантолгой транс" ХХК нь 2013-2017 онуудад "Тавантолгой" ХК-иас 11,660,000 тонн нүүрс худалдан авахаар гэрээ байгуулсан боловч "Тавантолгой" ХК-ийн санхүүгийн анхан шатны баримтаар "Тавантолгой транс" ХХК нь 1,793,248.67 тонн нүүрс худалдан авсан ба Гашуунсухайтын гаалийн газраар 2,185,463.95 тонн нүүрс экспортолсон нь худалдаж авсан нүүрсний тоо хэмжээнээс хэтэрсэн байгааг тогтоосон.

Гаалийн ерөнхий газрын ажлын хэсгийн дүгнэлтээр "Тавантолгой транс" ХХК нь 2013-2017 онуудад "Тавантолгой" ХК-иас 1,795,128.82 тонн нүүрс худалдан авсан бол 2013-2017 онуудад нийт 2,185,463.95 тонн нүүрс экспортолсон байна. Балансаар харахад 390,335.13 тонн нүүрсний зөрүү гарч байна. Дээрх илүү гарсан 390,335.13 тонн нүүрсний эх үүсвэр нь тодорхой бус тул хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай" гэсэн дүгнэлт гарсантай холбогдуулан цагдаагийн байгууллагаас 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн

17.4 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 180200318 дугаартай хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагаагаар “Таван толгой” ХК-ийн 2013-2017 оны санхүүгийн анхан шатны баримтад хөндлөнгийн аудитын компаниар санхүүгийн шинжилгээ хийлгэж, урьдчилсан дүгнэлт гаргуулсан байна. Хэргийг мөрдөн шалгах явцад дээрх компанийн 2012 оны санхүүгийн баримтад санхүүгийн шинжилгээ хийлгэх шаардлага гарсан бөгөөд дүгнэлт одоогоор гараагүй байна.

Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагаагаар “Таван толгой” ХК-иас нүүрс худалдан авдаг аж ахуйн нэгжүүд хил давуулан худалдан борлуулсан мөнгөө өөрсдийн дансаар авдаггүй бөгөөд шууд дээрх компанийн дансанд шилжүүлж байсан нь урьдчилсан байдлаар татвараас зайлсхийх гэмт хэрэг байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон тул холбогдох шалгалтыг хийлгүүлэхээр Татварын ерөнхий газарт нүүрс худалдан авагч аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг 2019 оны 3 дугаар сард хүргүүлсэн.

**Асуулга 3. Хил хамгаалах ерөнхий газраас гаргасан мэдээгээр 2013-2017 онуудад Гашуунсухайт боомтоор нийт 849.141 автомашин хилээр гарсан байгаа бол Гаалийн ерөнхий газрын мэдээгээр мөн онуудад 814.243 автомашин нүүрс тээвэрлэсэн тухай бүртгэлтэй байна. Дээрх 2 байгууллагын бүртгэлийн зөрүүнээс харахад 35.000 орчим автомашин хилээр хоосон гарсан байж болзошгүй байна. Үүнээс Гаалийн ерөнхий газрын бүртгэлээр 2013-2017 онуудад Гашуунсухайт боомтоор 2527 машин 17124 удаагийн давтамжтай хоосон гарсан бүртгэлтэй байгаагаас 59 аж ахуй нэгжийн 3982 машин олон удаагийн давтамжтайгаар хилээр хоосон гарсан нь нүүрс тээвэрлэсэн байх магадлалтай тул шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлсэн боловч одоог хүртэл ямар арга хэмжээ авсан талаар мэдээлэл огт байхгүй байна. Энэ талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын явц болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар:**

2013-2017 онуудад Гашуунсухайт боомтоор хилээр хоосон гарсан автомашинууд нүүрс тээвэрлэсэн байж болзошгүй асуудалд цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн 180200318 дугаартай хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Гаалийн ерөнхий газрын мэдээллийн сангийн бүртгэлээр Өмнөговь аймгийн Гашуунсухайтын боомтоор 2013-2017 онд нийт 2527 автомашин 17124 удаагийн давтамжтайгаар хилээр ачаагүй хоосон гарсныг нүүрс тээвэрлэдэг аж ахуйн нэгж, автомашин тус бүрээр жагсаалтаар гарган, тулгах ажиллагаа хийсэн.

Гаалийн болон Хил хамгаалах байгууллагын гаргасан авто тээврийн хэрэгслийн тоо 35,000 орчим зөрүүтэй байсныг машин тус бүрээр тулгалт хийхэд Хил хамгаалах байгууллагын гаргасан тээврийн хэрэгслийн тоо нь улсын хилээр нэвтэрч байгаа хүнд даацын болон суудлын автомашины нийт тоо хэмжээ, харин Гаалийн байгууллагаас гаргасан авто тээврийн тоо нь зөвхөн хүнд даацын буюу нүүрс тээврийн автомашины тоо байгаагаас дээрх 35,000 орчим авто тээврийн хэрэгслийн тооны зөрүү үүссэн байна.

Дээрх бүртгэлээр олон удаа хилээр гарсан 625 тээврийн хэрэгсэл /3955 удаа хилээр хоосон гарсан/-ийн мэдээллийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Гашуунсухайт авто зам” ХХК болон Гаалийн ерөнхий газарт хүргүүлж, авто замын төлбөрийн баримт, улсын хилээр нэвтрэхдээ бүрдүүлсэн гаалийн бүрдүүлэлтийн материалыг тус тус гаргуулан авахаар Цагдаагийн байгууллагаас 2019 оны 10а/1310 тоот албан бичгээр хандаж, хуулийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөн тус байгууллагаас Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад нүүрс импортолсон аж ахуй нэгж, тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тоо, нүүрсний хэмжээг

2013-2017 оны байдлаар гаргуулан авахаар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд 2019 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 10а/448 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлсэн боловч одоог хүртэл хариу ирүүлээгүй байна.

Жич: Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн албан бичгийн хуулбарыг хавсаргав.

-----oOo-----